



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/539

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157 дугаар захирамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08, 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хот хөдөөгийн сэргэлт” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотод “Нээлттэй Хөвсгөл” арга хэмжээ зохион байгуулсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/234 дүгээр захирамжийн хавсралтын 9 дүгээр мөрөнд батлагдсан “Үйл ажиллагаанд ашиглах байр, талбай, асрын тохижилт чимэглэл” зардлын зориулалтад өөрчлөлт оруулж, тээврийн зардалд 1,000.000 (Нэг сая), зохион байгуулалтын зардалд 1,050.000 (Нэг сая тавин мянга), уран бүтээлчдийн байрны зардалд 1,250.000 (Нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Төсвийг Засаг дарга дансны “Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах” зардлаас өөрчлөгдсөн зориулалтын дагуу гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР